MAGIC CONSULTING AUDIT

АУДИТ
БАТАЛГААЖУУЛАХ
ҮЙЛЧИЛГЭЭ

**КРЕДИТ ПРОГРЕСС ББСБ ХХК-ИЙН**
**2020 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР**
**ТАСАЛБАР БОЛГОСОН**



# АУДИТОРЫН ТАЙЛАН

**АГУУЛГА** 0

УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ 1
ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН 2-3

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН 4-5
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН 6
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН 7
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН 8

ТОДРУУЛГА 1 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө 9
ТОДРУУЛГА 2 Харилцагчдад олгосон зээл 9
ТОДРУУЛГА 3 Бусад авлага 10
ТОДРУУЛГА 4 Үндсэн хөрөнгө 10
ТОДРУУЛГА 5 Биет бус хөрөнгө 10
ТОДРУУЛГА 6 Бусад өр төлбөр 10
ТОДРУУЛГА 7 Дүрмийн сан 10
ТОДРУУЛГА 8 Хүү болон түүнтэй адилтгах орлого 10
ТОДРУУЛГА 9 Хүүгийн бус зардал 11
ТОДРУУЛГА 10 Бусад асуудал 11
ТОДРУУЛГА 11 Балансын дараах үйл явдал 11

**2020 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон**
**Санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах**
**Удирдлагын хариуцлагын мэдэгдэл**

Энэхүү мэдэгдэл нь "Кредит Прогресс ББСБ "Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн ("Компани" гэх) 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг ялгахад чиглэгдсэн болно.

Удирдлага нь Компанийн санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт(СТОУС)-уудын дагуу үнэ зөв бэлтгэх үүрэгтэй бөгөөд эдгээр санхүүгийн тайлангууд нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант хугацааны санхүүгийн гүйцэтгэл, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг СТОУС, Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль, холбогдох заавар журамд нийцүүлэн үнэн зөв, шударгаар илэрхийлсэн байх ёстой.

**Санхүүгийн тайланг бэлтгэхэд удирдлага дараах хариуцлагыг хүлээдэг.**
**Үүнд:**

- Компанийн үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгож, тууштай мөрдөх
- Ул үндэслэлтэй, хянамгай шийдвэр гаргах болон тооцоолол хийх
- СТОУС-ыг дагаж мөрдсөн эсэхээ дурдаж, хэрэв материаллаг зөрүү буюу өөрчлөлт байгаа бол түүнийг санхүүгийн тайланд тодруулж, тайлбарлах
- Компани ирээдүйд бизнесээ үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөл нь тохиромжгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайланг тасралтгүй үйл ажиллагаагаа явуулах төсөөлөлд үндэслэж бэлтгэх

**Удирдлага нь мөн түүнчлэн,**

- Дотоод хяналтын үр дүнтэй, тууштай систем боловсруулж, хэрэгжүүлж, ажиллуулах
- Компанийн санхүүгийн байдлыг үнэн зөвөөр, аливаа хугацаанд харуулахуйц нягтлан бодох бүртгэл хөтлөх ажиллагааг зохион байгуулах
- Компанийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхүйцээр зохион байгуулагдсан байх
- Хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Заль мэхний асуудал, алдаа болон бусад зөрчлийг илрүүлэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх зэрэг үүрэг хүлээдэг.

Бид эдгээр үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт, Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэ зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

УПАЛНБАЛТАР ХОТ
КРЕДИТ
ПРОГРЕСС ББСБ
ХХК
ХТУ6988 ф 5766303

Захирал _____

Ерөнхий Нягтлан Бодогч _____

Огноо: 2021.02.08

MAGIC CONSULTING AUDIT

**МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ ХХК**
Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
25-р хороо, Манлай Баатар Дамдинсүрэнгийн
гудамж, UB tower, 15 давхар, 1502 тоот.
Утас: 7013-1044. И-мэйл: info@magicgroup.mn
Вэб хуудас: www.magicgroup.mn

2021-03-22 дугаар 21-4B2104158

танай _____ -ны дугаар _____ -т

**"КРЕДИТ ПРОГРЕСС ББСБ" ХХК**-ийн
хувьцаа эзэмшигчид

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

## Дүгнэлт

Бид **"КРЕДИТ ПРОГРЕСС ББСБ"** ХХК ('Компани' гэх)-ийн 2020 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар Компанийн 2020 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-уудын дагуу үнэн зөв толилуулж байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЁЗОУСЗ)- өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЁЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

## Аудитын гол асуудлууд

Бидний гаргасан тайланд томоохон хэмжээний аудитын гол асуудал гараагүй гэж тодорхойлж байна.

## Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн тайлангийн талаар хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь СТОУС-уудын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.
Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр аргагүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах Компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ. Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлага хүлээдэг.

## Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилангаас эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үзнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээсэн үүрэг хариуцлагын тодорхойлолтыг Мэжик Консалтинг Аудит ХХК-ийн http://www.magicgroup.mn/mn/uureg вэб сайтад байршуулсан. Уг тодорхойлолт нь аудиторын тайлангийн нэг хэсэг юм.

## Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль" -ийн 94-р зүйлд заасан хуулийн этгээд болох "КРЕДИТ ПРОГРЕСС ББСБ" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

С.Мөнхбаяр
Мэргэшсэн нягтлан бодогч, Партнер
Мэжик Консалтинг Аудит ХХК

Улаанбаатар хот, Монгол Улс
2020 оны 03 дугаар сарын 11

**"КРЕДИТ ПРОГРЕСС ББСБ" ХХК**
**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**
**2019 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН**

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | тодотгол | 2019.12.31 | 2020.12.31 |
|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | |
| **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ** | | | |
| Мөнгөн хөрөнгө | 1 | 48,795,314.07 | 63,892,191.74 |
| Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/ | | - | - |
| Зээл /цэврээр/ | 2 | 1,605,620,013.91 | 1,114,099,274.24 |
| Санхүүгийн түрээсийн тооцооны авлага /цэврээр/ | | - | - |
| Факторингийн тооцооны авлага /цэврээр/ | | - | - |
| Бусад авлага | 3 | 183,436,785.94 | 722,155,406.10 |
| Бусад хөрөнгө | | - | - |
| Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө | | - | - |
| **Эргэлтийн хөрөнгийн нийт дүн** | | **1,837,852,113.92** | **1,900,146,872.08** |
| **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ** | | | |
| Үндсэн хөрөнгө | 4 | 1,509,000.00 | 3,279,672.00 |
| Биет бус хөрөнгө | 5 | 1,847,085.00 | 832,421.00 |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | | **3,356,085.00** | **4,112,093.00** |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | | **1,841,208,198.92** | **1,904,258,965.08** |
| **ӨР ТӨЛБӨР** | | | |
| **Богино хугацаат өр төлбөр** | | | |
| Бусад эх үүсвэр | | - | - |
| Салбар хоорондын тооцооны өглөг | | - | - |
| Ногдол ашгийн өглөг | | - | - |
| Цалингийн өглөг | 6 | | 1,651,635.00 |
| ЭМД,НДШ-ийн өглөг | | - | - |
| ХАОАТ-ын өглөг | 6 | 677,197.23 | 556,067.28 |
| Орлогын албан татварын өглөг | 6 | 8,804,395.78 | |
| Бусад | 6 | 3,489,753.00 | 2,000,000.00 |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | | **12,971,346.01** | **4,207,702.28** |
| **УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | | - | - |
| Банк, санхүүгийн байгууллагаас авсан урт хугацаат зээл | | - | - |
| Төслийн зээлийн урт хугацаат санхүүжилт | | 67,249,138.12 | - |
| **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | | - | - |
| **Нийт өр төлбөрийн дүн** | | **80,220,484.13** | **4,207,702.28** |
| **ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ** | | - | - |
| Энгийн хувьцаа | 7 | 1,583,300,000.00 | 1,583,300,000.00 |
| Давуу эрхтэй хувьцаа | | - | - |
| Халаасны хувьцаа | | - | - |
| **Хувьцаат капиталын дүн** | | **1,583,300,000.00** | **1,583,300,000.00** |
| Хуримтлагдсан ашиг /алдагдал/ | | 177,687,714.79 | 316,751,262.80 |
| **Эзэмшигчдийн өмчийн дүн** | | **1,760,987,714.79** | **1,900,051,262.80** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН** | | **1,841,208,198.92** | **1,904,258,965.08** |
| | | - | - |

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Тодотгол | 2019.12.31 | 2020.12.31 |
|---|---|---|---|
| **Хүүгийн орлого** | 8 | **288,508,553.11** | **334,294,225.16** |
| Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого | | 283,242,412.39 | 332,772,035.55 |
| Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого | | 143,200.49 | 1,494,665.34 |
| Харилцах дансны хүүгийн орлого | | 5,122,940.23 | 27,524.27 |
| **Хүүгийн бус орлого** | | **150,000.00** | **-** |
| **Хүүгийн бус зардал** | 9 | **(78,148,773.57)** | **(90,267,621.31)** |
| **ЦЭВЭР ХҮҮГИЙН БУС ОРЛОГО/ЗАРДЛЫН ДҮН** | | **(77,998,773.57)** | **(90,267,621.31)** |
| Зээлийн эрсдэлийн зардал | | | 99,221,732.75 |
| **ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ/АЛДАГДАЛ** | | **210,509,779.54** | **144,804,871.10** |
| Үндсэн бус үйл ажиллагааны орлого | | - | 2,066,410.12 |
| Үндсэн бус үйл ажиллагааны зардал | | 518,800.00 | 3,027,980.00 |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал** | | **209,990,979.54** | **143,843,301.22** |
| Орлогын татварын зардал | | 20,957,256.85 | 4,779,753.21 |
| **ЦЭВЭР АШИГ** | | **189,033,722.69** | **139,063,548.01** |

## ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Хувьцаат капитал | Халаасны хувьцаа | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2018 оны 12 сарын 31-р үлдэгдэл** | **1,583,300,000.00** | **-** | **(11,346,007.90)** | **1,571,953,992.10** |
| Бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | **-** |
| **Залруулсан үлдэгдэл** | 1,583,300,000.00 | **-** | **(11,346,007.90)** | **1,571,953,992.10** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт/бууралт | | - | | - |
| Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт/бууралт | | - | | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | - | | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй цэвэр олз, гарз | | - | | - |
| Тайлант үеийн цэвэр ашиг: | | - | 189,033,722.69 | 189,033,722.69 |
| Хуваарилсан ногдол ашиг | | - | | - |
| Хувьцаат капиталын өсөлт | | - | | - |
| **2019 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл** | **1,583,300,000.00** | **-** | **177,687,714.79** | **1,760,987,714.79** |
| Бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | - | | **-** |
| **Залруулсан үлдэгдэл** | 1,583,300,000.00 | **-** | **177,687,714.79** | **1,760,987,714.79** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт/бууралт | | - | | - |
| Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт, бууралт | | - | | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | - | | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй цэвэр олз, гарз | | - | | - |
| Тайлант үеийн цэвэр ашиг: | | - | 139,063,548.01 | 139,063,548.01 |
| Хуваарилсан ногдол ашиг | | - | - | - |
| Хувьцаат капиталын өсөлт | | - | | - |
| **2020 оны 12 сарын 31-р үлдэгдэл** | **1,583,300,000.00** | **-** | **316,751,262.80** | **1,900,051,262.80** |
| | | | - | - |

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2019.12.31 | 2020.12.31 |
|---|---|---|
| **Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн** | **(1,336,528,202.27)** | **17,624,857.67** |
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого** | **995,255,826.89** | **1,674,309,834.92** |
| Зээлийн хүүгийн орлого | 235,468,887.36 | 326,783,372.10 |
| Харилцах дансны хүүгийн орлого | 5,317,570.23 | 27,524.27 |
| Гадаад валютын арилжааны орлого | - | - |
| Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого | - | - |
| Хүүгийн орлогын буцаалт | - | - |
| Бусад үйлчилгээний орлого | 754,469,369.30 | 1,347,498,938.55 |
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага** | **2,331,784,029.16** | **1,656,684,977.25** |
| Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал | - | - |
| Үндсэн ба нэмэгдэл цалин | 24,294,947.34 | 29,614,899.00 |
| Ажилтануудад олгосон нөхөн олговор, тэтгэмж | - | - |
| Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал | 6,479,165.00 | 3,836,137.00 |
| Албан томилолт, сургалтын зардал | - | - |
| Ашиглалтын зардалд төлсөн мөнгө | - | 3,362,234.04 |
| Шатахуун, холбоо, интернет, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө | 3,556,140.00 | 7,726,589.70 |
| Бичиг хэргийн зардал, ариун цэврийн зардал | 387,780.00 | 334,215.00 |
| Татвар, даатгалын төлсөн мөнгө | 14,548,857.74 | 21,857,675.21 |
| Зар сурталчилгаанд төлсөн мөнгө | - | - |
| Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан зардал | 746,000.00 | 150,000.00 |
| Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээний мөнгө | 880,000.00 | 880,000.00 |
| Зохицуулалтын үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө | 1,980,000.00 | 2,580,000.00 |
| Ногдол ашгаар олгосон мөнгө | - | - |
| Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн бусад мөнгө | 221,227,000.00 | 1,002,321,739.00 |
| Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө | 2,057,684,139.08 | 584,021,488.30 |
| **Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | **(518,800.00)** | **(2,527,980.00)** |
| **Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого** | **-** | **-** |
| Үндсэн ба хөрөнгө борлуулсны орлого | - | - |
| Ногдол ашгийн орлого | - | - |
| Хандив | - | - |
| Бусад | - | 500,000.00 |
| **Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага** | **518,800.00** | **3,027,980.00** |
| Баяр ёслол, зочин төлөөлөгчийн зардал | 518,800.00 | - |
| Торгуулийн зардал | - | 1,235,980.00 |
| Бусад | - | 1,792,000.00 |
| **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **(1,337,047,002.27)** | **15,096,877.67** |
| **МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ** | **1,385,842,316.34** | **48,795,314.07** |
| **МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ** | **48,795,314.07** | **63,892,191.74** |

## 1 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

| Үзүүлэлт | 2019.12.31 | 2020.12.31 |
|---|---|---|
| Касс дахь бэлэн мөнгө | 44,232,236.78 | 1,067,704.51 |
| Банкин дахь мөнгөн хөрөнгө | 4,563,077.29 | 62,824,487.23 |
| | **48,795,314.07** | **63,892,191.74** |

2020-12-31-ний байдлаар Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн 98.33 хувийг банкинд байгаа мөнгөн хөрөнгө, 1.67 хувийг гар дээр байгаа мөнгөн хөрөнгө эзэлж байна. Мөн нийт хөрөнгийн 3.36 хувийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө эзэлж байна.

## 2 Харилцагчдад олгосон зээл

| Үзүүлэлт | 2019.12.31 | 2020.12.31 |
|---|---|---|
| Харилцагчдад олгосон зээл | 1,605,620,013.91 | 1,213,321,006.99 |
| Нийт зээл /цэврээр/ | 1,605,620,013.91 | 1,114,099,274.24 |
| | - | **99,221,732.75** |

Зээлийн ангилал

| Үзүүлэлт | 2019.12.31 | 2020.12.31 |
|---|---|---|
| Хэвийн зээл | 1,520,955,934.30 | 1,083,370,330.17 |
| Хугацаа хэтэрсэн зээл | 84,664,079.61 | - |
| Хэвийн бус зээл | - | 32,342,581.88 |
| Эргэлзээтэй зээл | - | 12,944,015.33 |
| Муу | - | 84,664,079.61 |
| | **1,605,620,013.91** | **1,213,321,006.99** |

2020-12-31-ны байдлаар 89.29 хувийг хэвийн зээл, 2.66 хувийг хэвийн бус зээл, 1.07 хувийг эргэлзээтэй зээл, 6.98 хувийг муу зээл эзэлж байна. Нийт хөрөнгийн 63.85 хувийг эзэлж байна.

| Зээлийн ангилал | |
|---|---|
| Хувийн сектор | - |
| Иргэд | 1,213,321,006.99 |
| | **1,213,321,006.99** |

2020-12-31-ны өдрийн байдлаар нийт зээлийн 100.00 хувийг иргэдэд олгосон зээл эзэлж байгаа бөгөөд Банк Бус Санхүүгийн Үйл Ажиллагааны Тухай хуулийн 13 дугаар зүйл 13.1-д "Банк бус санхүүгийн байгууллагаас нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгох зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүн нь тухайн банк бус санхүүгийн байгууллагын өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрч болохгүй" гэж заасныг зөрчөөгүй байна. 2020-12-31-ны байдлаар 89.29 хувийг хэвийн зээл, 2.66 хувийг хэвийн бус зээл, 1.07 хувийг эргэлзээтэй зээл, 6.98 хувийг муу зээл эзэлж байна. Нийт хөрөнгийн 63.85 хувийг эзэлж байна. Зээлийн эрсдлийн санд байршуулсан 99,221,732.75 төгрөг байна.

### 3 Бусад авлага

| Үзүүлэлт | 2019.12.31 | 2020.12.31 |
|---|---|---|
| Бусад авлага | 150,000,000.00 | 699,678,187.81 |
| Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага | 33,436,785.94 | 22,477,218.29 |
| | **183,436,785.94** | **722,155,406.10** |

### 4 Үндсэн хөрөнгө

| Үзүүлэлт | 2019.12.31 | 2020.12.31 |
|---|---|---|
| Барилга байгууламж | - | |
| Хуримтлагдсан элэгдэл /барилга байгууламж/ | - | |
| Эд хогшил | 1,480,000.00 | 3,742,740.00 |
| Хуримтлагдсан элэгдэл /эд хогшил/ | (184,200.00) | (463,068.00) |
| Техник хэрэгсэл | 1,330,000.00 | 1,330,000.00 |
| Хуримтлагдсан элэгдэл /эд хогшил/ | (1,116,800.00) | (1,330,000.00) |
| | **1,509,000.00** | **3,279,672.00** |

Үндсэн хөрөнгө нь Нийт хөрөнгийн 0.17 хувийг эзлэж байна.

### 5 Биет бус хөрөнгө

| Үзүүлэлт | 2019.12.31 | 2020.12.31 |
|---|---|---|
| Биет бус хөрөнгө | 1,847,085.00 | 832,421.00 |
| | **1,847,085.00** | **832,421.00** |

Интерактив Би Ай ХХК-ний Спинел 6.0 програм хангамжийг биет бус хөрөнгөөр бүртгэсэн байна.

### 6 Бусад өр төлбөр

| Үзүүлэлт | 2019.12.31 | 2020.12.31 |
|---|---|---|
| Цалингийн өглөг | - | 1,651,635.00 |
| ХХОАТ-ын өглөг | 677,197.23 | 556,067.28 |
| Орлогын албан татварын өглөг | 8,804,395.78 | - |
| Бусад | 3,489,753.00 | 2,000,000.00 |
| | **12,971,346.01** | **4,207,702.28** |

2020-12-31-ны байдлаар бусад өр төлбөрийн 13.22 хувийг татварын өр төлбөр эзэлж байна.

### 7 Дүрмийн сан

| Үзүүлэлт | 2019.12.31 | 2020.12.31 |
|---|---|---|
| Дүрмийн сан | 1,583,300,000.00 | 1,583,300,000.00 |
| Хувьцаа /ширхэг/ | 1,583,300.00 | 1,583,300.00 |

2020 оны 10 сарын 31-ны байдлаар хувьцаат капитал нь нэг бүр нь 1,000 төгрөгийн үнэтэй 1,583,300.00 ширхэг хувьцаанаас бүрдэж байна.

### 8 Хүү болон түүнтэй адилтгах орлого

| Үзүүлэлт | 2019.12.31 | 2020.12.31 |
|---|---|---|
| Зээлийн хүүний орлого | 283,385,612.88 | 334,266,700.89 |
| Харилцах дансны хүүний орлого | 5,122,940.23 | 27,524.27 |
| | **288,508,553.11** | **334,294,225.16** |

## 9 Хүүгийн бус зардал

| Үзүүлэлт | 2019.12.31 | 2020.12.31 |
|---|---|---|
| Үндсэн болон нэмэгдэл цалин | 28,310,976.00 | 32,264,935.00 |
| Гэрээгээр ажиллагсдын ажлын хөлс | | 2,000,000.00 |
| Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал | 3,374,565.00 | 4,033,117.12 |
| Сургалтын зардал | 895,000.00 | 928,000.00 |
| Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан зардал | 746,000.00 | 150,000.00 |
| Аудитын төлбөр, мэргэжлийн үйлчилгээ | 880,000.00 | 880,000.00 |
| Даатгал | 911,180.00 | 89,100.00 |
| Түрээс | 24,000,000.00 | 24,000,000.00 |
| Ашиглалтын зардал/цахилгаан, уур ус, дулаан, цэвэр, бохир ус/ | - | 3,362,234.04 |
| Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал | 1,466,115.00 | 1,935,732.00 |
| Харилцаа холбоо, интернет | 3,236,140.00 | 7,726,589.70 |
| Сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээ | 320,000.00 | - |
| Зохицуулалтын хураамжийн зардал | 1,980,000.00 | 2,580,000.00 |
| Захиалгат хэвлэлийн зардал | - | 130,000.00 |
| Автоматжуулалттай холбоотой урсгал зардал | 10,242,000.00 | 9,076,162.00 |
| Бичиг хэргийн зардал | 387,780.00 | 334,215.00 |
| Бусад | 1,399,017.57 | 777,536.45 |
| | **78,148,773.57** | **90,267,621.31** |

Компани нь өдөр тутмын үйл ажиллагаа явуулахын тулд хүүгийн бус зардлуудыг гаргадаг байна. 2019-12-31-ны байдлаар хүүгийн бус зардлын 36.74 хувийг цалингийн зардал эзэлж байна.

## 10 Бусад асуудал

2020 оны 12 сарын 31-ний байдлаар 18,849,125.69 төгрөгийн хуримтлуулсан хүүгийн авлага бүхий 93,891,495.81 төгрөгийн үндсэн зээлийн нэхэмжлэгчээр оролцож байгаа шийдвэрлэгдээгүй шүүхийн нэхэмжлэх байна.
2020 оны 12 сарын 31-ний байдлаар 10,769,142.00 төгрөгийн нэхэмжлэлийн шүүхийн хариуцагчаар оролцож байна

## 11 Балансын дараах үйл явдал

2021 оны 01 сарын 01-нээс 2021 оны 03 сарын 22 өдөр хүртэл КРЕДИТ ПРОГРЕСС ББСБ ХХК-ийн санхүүгийн тайлангуудад нөлөөлөхүйц, тодруулахыг шаарддаг үйл явдал гараагүй байна.

Аудитор_____Н.Мөнхзаяа /Мэргэшсэн нягтлан бодогч/
Туслах аудитор_____Г.Балдандорж /Бүртгэл санхүүгийн мэргэжилтэн/

2021 оны 03 сарын 22-ны өдөр

# **ҮНДЭСНИЙ АУДИТЫН** КОМПАНИ

Since 2007




**МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ ХХК**

Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 25-р хороо, UB Tower, 15-р давхар, 1502 тоот

**Утас:** 7013-1044 **Цахим хуудас:** www.magicgroup.mn **Э-шуудан:** audit@magicgroup.mn